



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн
дуудлага худалдааг дахин зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2025 оны 120 дүгээр тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 188 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжийн хүрээнд зохион байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдаанд ялагч тодроогүй 1 (нэг) байршилд 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр дахин цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 сарын 31-ны өдрийн 07.000 дугаар
захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ,
АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2-аар)	Газрын анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн төлбөр 10% (төгрөг)
1	БХД 2-р хороо, Хуучин нүүрсний уурхайн баруун урд талд	Жимс жимсгэний усалгаагүй тариалан	273773	4,762,281	476,228.1